



Залгамж халааны бодлого

“Монголиан Файнэншил Партнерс ББСБ” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн  
2026 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн  
МФП-26/10-03 тоот хурлын тогтоолын Дөрөвдүгээр хавсралт

## **ЗАЛГАМЖ ХАЛААНЫ БОДЛОГО**

### **НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

- 1.1. Энэхүү журмаар -ийн Залгамж халааны бодлого нь “Монголиан файнэншил партнерс ББСБ” ХХК (цаашид "ББСБ" гэх)- ийн үйл ажиллагааны тасралтгүй, хэвийн байдлыг хангах, эрх бүхий албан тушаалтан гэнэт, эсхүл төлөвлөгөөний дагуу өөрчлөгдөхөд эрх бүхий албан тушаалтныг нэр дэвшүүлэх, сонгон шалгаруулах, томилохтой холбоотой харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Энэхүү бодлогыг шинэчлэх, хүчингүй болгох асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолоор шийдвэрлэнэ.

### **ХОЁР. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ**

- 2.1 Энэхүү бодлогод хэрэглэсэн нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:
  - 2.1.1 **"Эрх бүхий албан тушаалтан"** гэж Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга болон Гүйцэтгэх захирлыг;
  - 2.1.2 **"Нэр дэвшүүлэх хороо"** гэж Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдээс бүрдсэн, Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороог.

### **ГУРАВ . ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ЗАЛГАМЖ ХАЛАА**

- 3.1 Нэр дэвшүүлэх хороо нь ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүн, нарийн бичгийн дарга, Гүйцэтгэх захиралд тавигдах шаардлага, шалгуурыг Компанийн дүрэм, Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм, журам холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн тогтооно.
- 3.2 Нэр дэвшүүлэх хороо нь эрх бүхий албан тушаалтны сонгон шалгаруулалтыг дотоод нөөц, эсхүл гаднаас сонгох эсэхийг шийдвэрлэж, сонгон шалгаруулалтыг зарлана.
- 3.3 Нэр дэвшүүлэх хороо нь гэнэтийн тохиолдолд шууд нэр дэвшүүлэх боломжтой хүмүүсийн жагсаалтыг гаргана.
- 3.4 ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь сонгон шалгаруулалтад ирүүлсэн нэр дэвшигчдийн баримт, материалыг хадгална.

### **ДӨРӨВ. ГЭНЭТИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА**

- 4.1 Нэр дэвшүүлэх хороо нь эрх бүхий албан тушаалтанд дараах нөхцөл байдлын аль нэг нь үүссэн тохиолдолд ажлын 5 хоногийн дотор хуралдаж, эрх бүхий албан тушаалтныг түр орлох, эсхүл шинээр томилох этгээдийн мэдээллийг бэлтгэн Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулна. Үүнд:
  - 4.1.1 Нас барсан;
  - 4.1.2 Хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан;
  - 4.1.3 Өвчтэй байх;
  - 4.1.4 Жирэмсний болон амаржсаны амралттай, хүүхэд асрах чөлөөтэй байх;
  - 4.1.5 Урьдчилан тооцоолох боломжгүй нөхцөл байдлын улмаас албан үүргээ гүйцэтгэх боломжгүй болох
- 4.2 ТУЗ нь ТУЗ-ийн гишүүнийг түр орлох, эсхүл ТУЗ-ийн гишүүнээр шинээр томилогдох этгээдийн мэдээллийг Хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулна.
- 4.3 ТУЗ-ийн гишүүдийг Хувьцаа эзэмшигчдээс, Гүйцэтгэх захирал болон ТУЗ-ийн нарийн бичгийн даргыг Төлөөлөн удирдах зөвлөлөөс томилно.
- 4.4 Гүйцэтгэх захирал энэхүү бодлогын 4.1.3-4.1.5 дахь хэсэгт заасны дагуу ажил үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон тохиолдолд түр орлон ажиллах этгээдийг Төлөөлөн удирдах зөвлөлөөс томилно.

## ТАВ . ТАЙЛАГНАЛ, ХЯНАЛТ

- 5.1 “Монголиан файнэншл партнерс ББСБ” ХХК нь энэхүү бодлогын баримт бичигтэй холбоотой мэдээллийг өөрийн цахим хуудастаа байршуулж болох бөгөөд энэ нь “Монголиан файнэншл партнерс ББСБ” ХХК-ийн Мэдээллийн ил тод байдлын журамд нийцсэн байна.
- 5.2 “Монголиан файнэншл партнерс ББСБ” ХХК нь Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд болон Гүйцэтгэх захирлын мэдээллийг өөрийн цахим хуудсандаа ил тод, нээлттэй байршуулах бөгөөд нээлттэй, ил тод байршуулсан эсэхэд Гүйцэтгэх захирал хяналт тавьж ажиллана.

## ЗУРГАА. БУСАД

- 6.1 Энэхүү журмыг ТУЗ-ийн хурлаар баталж, тогтоол гарснаар хүчин төгөлдөр дагаж мөрдөгдөнө.
- 6.2 Бодлогын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах эрх гагцхүү ТУЗ-д хадгалагдана. ТУЗ-өөс нэмэлт, өөрчлөлт оруулах үндэслэлтэй гэж үзвэл ТУЗ-ийн хурлын тогтоолоор баталгаажуулна.
- 6.3 ТУЗ-өөс баталсан нэмэлт, өөрчлөлт нь энэхүү журмын нэгэн адил хүчин төгөлдөр үйлчилнэ.
- 6.4 Энэхүү журмаар зохицуулаагүй аливаа харилцааг Монгол улсын Компанийн тухай хууль, Иргэний хууль, компанийн дүрэм болон бусад холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актад заасны дагуу зохицуулна.

---oOo---